

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хайрхан сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2026/019/-НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Архангай аймаг 2026 он	Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: <a href="mailto:Baigalmaat@audit.gov.mn">Baigalmaat@audit.gov.mn</a> Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: <a href="mailto:Nerguibaatar@audit.gov.mn">Nerguibaatar@audit.gov.mn</a> Аудитор Н.Дашмягмар Цахим хаяг: <a href="mailto:Dashmyagmarn@audit.gov.mn">Dashmyagmarn@audit.gov.mn</a>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,  
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,  
Утас/Факс: (976) 7033 3141,  
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2026.03.25 № 170

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

АРХАНГАЙ АЙМГИЙН  
ХАЙРХАН СУМЫН ЗАСАГ ДАРГА  
В.МӨНХБАТ ТАНАА

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Архангай аймгийн Хайрхан сумын Төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Архангай аймгийн Хайрхан сумын төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн залруулагдаагүй 87,062.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй. Үүнд:

1. Сумын 2025 оны төсвийн орлогын төлөвлөгөө нийт дүнгээр 87,409.9 мянган төгрөгөөр давсан боловч 4 нэр төрлийн орлогыг төлөвлөснөөс 7,744.4 мянган төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн;
2. Хоршоо хөгжүүлэх сангийн 1 зээлдэгчтэй холбоотой 5,000.0 мянган төгрөгийн чанаргүй хугацаа хэтэрсэн авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй; зэрэг нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.49, 41 дүгээр зүйлийн 41.2.1, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын тушаалаар баталсан "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах,

эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 3 дугаар зүйлийн 3.4.11, 10 дугаар зүйлийн 10.1, 11 зүйлийн 11.3 дахь заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### **Аудитын гол асуудал**

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд ЗДТГ, ИТХ, "Хайрхан хөгжлийн дэд бүтэц" ОНӨААТҮГ, ОНХС, ХХС-ийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, ЕБС, Хүүхдийн цэцэрлэг, ЭМТ, Соёлын төвийн тогтмол зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийг нэгтгэсэн байна. Тус байгууллага нь орон нутгийн гүйцэтгэл засаглалын удирдлага, орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, орон нутгийн төсөвт олгох орлогын шилжүүлэг, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, соёл урлаг, ерөнхий боловсрол, эрүүл мэндийн бодлого удирдлага, сургуулийн өмнөх боловсрол гэсэн 8 хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр 2,759,905.6 мянган төгрөгийн санхүүжилт авч гүйцэтгэлээр 2,396,557.9 мянган төгрөгийг зарцуулсан байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Цахир сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2025 онд аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээгээр 15 үндсэн зорилтын хүрээнд 112 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг аймгийн Засаг даргын тамгын газрын хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсээс 76 хувьтай үнэлсэн байна.

*Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.*

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж олох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,060,642.29	888,650.86
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	732,660.58	509,249.62
33	АВЛАГА	185,066.61	271,288.56
34	БАРАА МАТЕРИАЛ	142,915.09	108,112.68
35	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,115,292.12	8,402,175.9
2	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,115,292.12	8,402,175.9
39	Биет хөрөнгө	3,097,741.84	8,384,835.4
39200	Биет бус хөрөнгө	17,550.28	17,340.5
39300	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	4,175,934.41	9,290,826.76
3	НИЙТ ӨР ТӨЛБӨР	103,665.19	72,130.96
4	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	103,665.19	72,130.96
41	Өглөг	103,665.19	72,130.96
41300	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,072,269.21	9,218,695.8
5	Засгийн газрын хувь оролцоо	4,072,269.21	9,218,695.8
51	Засгийн газрын оруулсан капитал	450,071.43	450,071.43
51100	Хуримтлагдсан үр дүн	3,074,865.24	8,211,483.41
51200	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	547,332.54	547,332.54
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	4,175,934.41	9,290,826.76

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,425,011.03	7,634,837.47
11	ТАТВАРЫН ОРЛОГО	726,392.64	640,375.17
110	Орлогын албан татвар	599,615.55	543,778.57
1100	Хувь хүний орлогын албан татвар	599,368.05	576,058.6
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0.0	-32,422.59
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	247.5	142.56
113	Хөрөнгийн албан татвар	80,649.36	61,182.61
118	Бусад татвар, төлбөр, хураамж	46,127.73	35,413.98
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	800,394.07	6,994,462.31
120	Нийтлэг татварын бус орлого	0.0	1,257,485.01
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,898,224.32	0.0
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,575,334.49	2,466,551.24
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,575,334.49	2,466,551.24
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,515,191.42	2,450,730.44
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	647,946.41	797,340.87
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	80,544.12	132,751.06
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	898,765.6	684,331.16
2104	Хангамж, бараа материалын зардал	81,116.44	66,775.77
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	48,612.64	78,247.06
2107	Томилолт, зочны зардал	5,949.6	8,135
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	383,551.64	335,357.93
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	368,704.97	347,791.6

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	60,143.06	15,820.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	849,676.55	5,168,286.23
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	273,195.6	31,668.07
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	576,480.94	5,136,618.16

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,071,243.45	2,591,899.43
11	ТАТВАРЫН ОРЛОГО	726,392.64	640,375.17
110	Орлогын албан татвар	599,615.55	543,778.57
1100	Хувь хүний орлогын албан татвар	0.0	-32,422.59
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	247.5	142.56
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	80,649.36	61,182.61
113	Хөрөнгийн албан татвар	46,127.73	35,413.98
118	Бусад татвар, төлбөр, хураамж	29,305.17	23,104.76
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	6,576.33	5,702.83
1181	Газрын төлбөр	10,246.23	6,606.39
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	446,626.48	1,951,524.26
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	446,626.48	502,302.7
120	Нийтлэг татварын бус орлого	0.0	1,257,485.01
121	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.0	191,736.55
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,898,224.32	0.0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,316,377.28	2,227,781.91
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,316,377.28	2,227,781.91
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,256,234.22	2,211,961.11
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	721,874.69	886,579.98
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	106,583.79	132,751.06
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	935,198.07	734,087.41
2104	Хангамж, бараа материалын зардал	226,151.29	248,610.79
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	51,972.64	74,948.06
2107	Томилолт, зочны зардал	5,949.6	8,135
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	53,916.22	58,076.01
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	154,587.93	68,772.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	60,143.06	15,820.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	754,866.17	364,117.52
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	407,077.89	437,528.49
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	407,077.89	437,528.49
2200	Дотоод эх үүсвэрээр	407,077.89	437,528.49
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-407,077.89	-437,528.49
VI	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0.0	150,000
VI	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0.0	-150,000
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	347,788.28	-223,410.97
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	384,872.31	732,660.58
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	732,660.58	509,249.62

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,495,788.27	3,495,788.27
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,495,788.27	3,495,788.27
3	Тайлант үеийн үр дүн	576,480.94	576,480.94
9	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,072,269.21	4,072,269.21
10	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	4,072,269.21	4,072,269.21
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-9,808.43	-9,808.43
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,082,077.64	4,082,077.64
19	Тайлант үеийн үр дүн	5,136,618.16	5,136,618.16
20	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	9,218,695.8	9,218,695.8

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	793,528.40	732,912.77	60.62	92.36
11	Татварын орлого	560,541.70	640,375.17	(79.83)	114.24
110	Орлогын албан татвар	519,240.00	543,778.57	(24.54)	104.73
1100	Хувь хүний орлогын албан татвар	553,108.00	576,058.60	(22.95)	104.15
110001	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	382,000.00	415,633.97	(33.63)	108.80
110002	Үйл ажиллагааны орлого	32,064.00	8,071.42	23.99	25.17
110003	Хөрөнгийн орлого	130,400.00	148,241.31	(17.84)	113.68
110004	Хөрөнгө борлуулсны орлого	8,500.00	3,743.40	4.76	44.04
110008	Шууд бус орлого	144.00	368.50	(0.22)	255.90
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(34,000.00)	(32,422.59)	(1.58)	95.36
110101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(34,000.00)	(32,422.59)	(1.58)	95.36
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татвар	132.00	142.56	(0.01)	108.00
113	Хөрөнгийн албан татвар	7,079.00	61,182.61	(54.10)	864.28
113001	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	4,709.00	11,483.11	(6.77)	243.85
113002	Бууны албан татвар	2,370.00	690.00	1.68	29.11
113004	Малд ногдуулах албан татвар	-	49,009.50	(49.01)	
118	Бусад татвар, төлбөр, хураамж	34,222.70	35,413.98	(1.19)	103.48
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	22,674.20	23,104.76	(0.43)	101.90
118001	Улсын тэмдэгтийн хураамж	2,773.40	1,465.60	1.31	52.84
118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	19,900.80	21,639.16	(1.74)	108.74

Архангай аймгийн Хайрхан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

1181	Газрын төлбөр	5,831.40	5,702.83	0.13	97.80
118101	Газрын төлбөр	5,331.40	5,702.83	(0.37)	106.97
118102	Дуудлага худалдаа	500.00	-	0.50	-
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	5,717.10	6,606.39	(0.89)	115.55
118201	Ойн нөөц ашигласны төлбөр	5,588.10	6,395.39	(0.81)	114.45
118202	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	129.00	211.00	(0.08)	164
12	Татварын бус орлого	232,986.70	92,537.60	140.45	39.72
120	Нийтлэг татварын бус орлого	232,986.70	92,537.60	140.45	39.72
120003	Торгуулийн орлого	5,000.00	11,564.76	(6.56)	231.30
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	227,686.70	79,661.09	148.03	34.99
120009	Бусад орлого	300.00	1,311.75	(1.01)	437.25
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,759,905.60	2,297,160.66	462.74	83.23
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,013,724.00	1,742,504.17	271.22	86.53
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,991,224.00	1,726,689.17	264.53	86.71
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	841,665.70	798,474.32	43.19	94.87
210101	Үндсэн цалин	837,705.70	521,244.17	316.46	62.22
210102	Нэмэгдэл	-	258,516.40	(258.52)	
210104	Урамшуулал	-	14,756.26	(14.76)	
210105	Гэрээт ажлын хөлс	3,960.00	3,957.48	0.00	99.94
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	105,208.30	99,397.31	5.81	94.48
210201	Тэтгэврийн даатгал	71,541.80	67,606.36	3.94	94.50
210202	Тэтгэмжийн даатгал	8,416.60	7,900.20	0.52	93.86
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,208.30	4,033.27	0.18	95.84
210204	Ажилгүйдлийн даатгал	4,208.30	3,950.11	0.26	93.86
210205	Эрүүл мэндийн даатгал	16,833.30	15,907.37	0.93	94.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	721,885.80	684,331.16	37.55	94.80
210301	Гэрэл, цахилгаан	76,504.20	50,767.72	25.74	66.36
210302	Түлш, халаалт	593,121.60	591,143.43	1.98	99.67
210303	Цэвэр, бохир ус	52,260.00	42,420.00	9.84	81.17
2104	Хангамж, бараа материалын зардал	73,338.50	55,608.08	17.73	75.82
210401	Бичиг хэрэг	10,894.70	7,406.40	3.49	67.98
210402	Тээвэр, шатахуун	34,619.70	25,319.78	9.30	73.14
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,568.00	6,503.40	1.06	85.93
210404	Ном, хэвлэл	800.00	316.00	0.48	39.50
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	13,455.70	12,050.00	1.41	89.55

**Архангай аймгийн Хайрхан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,000.40	4,012.50	1.99	66.87
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	119,800.00	98,734.86	21.07	82.42
210601	Багаж, техник, хэрэгсэл	20,400.00	19,796.80	0.60	97.04
210602	Тавилга	5,000.00	-	5.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,000.00	1,339.30	3.66	26.79
210604	Урсгал засвар	89,400.00	77,598.76	11.80	86.80
2107	Томилолт, зочны зардал	10,240.00	8,135.00	2.11	79.44
210702	Дотоод албан томилолт	10,240.00	8,135.00	2.11	79.44
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	28,016.10	9,012.16	19.00	32.17
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	24,589.10	7,223.86	17.37	29.38
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600.00	-	0.60	-
210803	Даатгалын үйлчилгээ	620.00	251.98	0.37	40.64
210804	Тээврийн хэрэгслийн татвар	230.00	188.18	0.04	81.82
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	77.00	66.00	0.01	85.71
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	900.00	450.00	0.45	50.00
210807	Газрын төлбөр	1,000.00	832.13	0.17	83.21
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	91,069.60	72,393.60	18.68	79.49
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	88,100.00	71,207.10	16.89	80.83
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,969.60	1,186.50	1.78	39.95
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,500.00	2,090,670.57	(2,068.17)	9,291.87
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	18,500.00	2,088,895.57	(2,070.40)	11,291.33
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	18,500.00	14,040.00	4.46	75.89
213103	Төсвийн санхүүжилт	-	2,074,855.57	(2,074.86)	
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,000.00	1,775.00	2.23	44.38
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,000.00	1,775.00	2.23	44.38
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	522,494.90	404,656.49	117.84	77.45
221001	Их засвар	19,800.00	-	19.80	-
222001	Тоног төхөөрөмж	175,000.00	169,958.73	5.04	97.12
223001	Бусад хөрөнгө	327,694.90	234,697.76	93.00	71.62
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	223,686.70	150,000.00	73.69	67.06
230001	Эргэж төлөгдөх зээл	223,686.70	150,000.00	73.69	67.06
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	1,291,329.90	(613,381.94)	1,904.71	(47.50)
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(1,291,329.90)	613,381.94	(1,904.71)	(47.50)
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(1,291,329.90)	613,381.94	(1,904.71)	(47.50)

4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	731,803.25	(731.80)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	508,499.11	(508.50)	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2	2	0.00	100.00
610001	Төсвийн байгууллага	2	2	0.00	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	26	26	0.00	100.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Дансны код	Дансны нэр, төрөл	Тайлант он
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	8,880.51
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,880.51
122	Тусламжийн орлого	8,880.51
1221	Хандив тусламж /дотоод/	8,880.51
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,880.51
350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,495.51
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,385.00
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,874.71
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,874.71
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,874.71
2104	Хангамж, бараа материалын зардал	1,688.02
210402	Тээвэр, шатахуун	1,538.02
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	150.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,807.49
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,807.49
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,379.20
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,379.20
4	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	5.80

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй.

Аудитаар залруулагдаагүй 2 зөрчилтэй асуудлын материаллаг мөнгөн дүн 12,744.7 мянган төгрөг бөгөөд гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 41,398.5 мянган төгрөгөөс бага, сумын засаг даргын санхүүгийн алба, төрийн сангаас өдөр тутам төсвийн гүйлгээнд тавих хяналтгүйгээс орон нутгийн удирдлагын байгууллагуудын тайланд 87,062.1 мянган төгрөгийн материаллаг зөрчил илэрч хязгаарлалттай дүгнэлт авсан байх тул Хайрхан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд **“Хязгаарлалттай” дүгнэлт** өглөө.

### 3.1 Албан шаардлага

3.1.1 Сумын төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлээр 4 нэр төрлийн орлого 7,744.4 мянган төгрөгөөр тасарсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

**Өгсөн албан шаардлага:** Сумын орлогыг нэр төрлөөр нь жигд ханган биелүүлэхэд анхаарч ажиллах, орлогын сар улирлын төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж ажиллах.

3.1.2 Хоршоо хөгжүүлэх сангаас олгосон 1 зээлдэгчтэй холбоотой 5,000.0 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй байна.

Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын А/361 дүгээр тушаалаар баталсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 3.4.11-д “Сангаас олгосон зээлийн эргэн төлөлтийн төлбөрийг зээлдэгч төлөхгүй тохиолдолд сумын Засаг дарга уг төлбөрийг төлүүлэх арга хэмжээг авч зээлийн дансанд төвлөрүүлнэ”, 10.1-д “Хяналтын зөвлөл нь зээлдэгчтэй байгуулсан зээлийн гэрээ, эргэн төлөлтийн хуваарийн дагуу зээлийн эргэн төлөлт, зээлийн хүү, алдангийг тухай бүр төлүүлж буйд хяналт тавина”, 11 дүгээр зүйлийн 11.3-т “Энэ журмыг зөрчсөн гэм буруутай этгээд санд учирсан хохирлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцан барагдуулна” гэсэн заалтыг зөрчиж байна.

**Шийдвэрлэсэн:** Хоршоо хөгжүүлэх сангийн чанаргүй зээлийн авлагыг барагдуулах талаар үр дүнтэй арга хэмжээ авч, зээлийн эргэн төлөлтөд хяналт тавьж ажиллах албан шаардлага хүргүүлэх

*Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.*

## 4. ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИД НЭГТГЭГДСЭН БАЙГУУЛЛАГУУДЫН ЗӨРЧИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ИТХ	2	0			2	0						
ЗДТГ	2	304,284.9			2	304,284.9						
Хайрхан хөгжлийн дэд бүтэц ОНӨААТҮГ	4	85,624.6			4	85,624.6						
ХХС	1	5,000.0			1	5,000.0						
Орлоготой холбоотой	1	7,744.4			1	7,744.4						
Хайрхан Эрүүл мэндийн төв /Тогтмол зардал/	1	1,437.5	1	1,437.5								

Архангай аймгийн Хайрхан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Нийт дүн	11	404,091.4	1	1,437.5	10	405,528.9						
----------	----	-----------	---	---------	----	-----------	--	--	--	--	--	--

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
ЗДТГ	1	0	1	0				
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	1	0	1	0				